

**“Тоочсон эх дэх зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл
ЗНӨ-ийн онцлог, хэрэглээ” бататгах хичээл**

Хичээлийн зорилго

- Зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл
- ЗНӨ-ийн онцлог, хэрэглээг сэргээн санах, бататгах

Эх уншиж задлан шинжилье

Ямар зорилгоор “Номын баяр” аяныг зохион байгуулах болсныг

Аянаар зохин байгуулсан ажлуудыг нэг цагт зэрэгцүүлэн тоочин бичсэн.

.....дүүргийн сургууль

Илтгэх хуудас

Аянаар зохион байгуулсан ажлуудын дэс дараалал, байрыг сольж үзэхэд эхийн утга өөрчлөгдөхгүй байна. Яагаад гэвэл өгүүлбэрүүд хоорондоо хэлэх аялга буюу үндсээр холбогдож зэрэгцсэн.

“Номын баяр” сарын аян явуулсан тухай

2013 оны 03 дүгээр сарын 20

Улаанбаатар

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2012 оны А/51 дүгээр тушаалаар батлагдсан **өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх, ном унших хэрэгцээ сонирхлыг нэмэгдүүлэх, танин мэдэхүйг хөгжүүлэх** зорилгоор хэрэгжүүлж буй “Ном” хөтөлбөрийн хүрээнд 2013 оны 02 сарын 20-ноос 03 дугаар сарын 20 –ны хооронд тус сургуульд “Номын баяр” сарын аян зохион байгууллаа.

Аянаар **эцэг, эхчүүдийг хүүхдийн ном бүтээх бүтээлч ажилд оролцуулах**, хүүхдэд зориулсан бүтээлийн сантай болгох зорилгоор **ном зохиох уралдаан**, “Ном миний хөгжлийн гарц” сэдэвт **эсээ бичлэгийн уралдаан**, **“Ухаан далай номоос эхтэй” сургалт сурталчилгааг зохион байгуулж, ангийн номын сантай болох хөдөлгөөн өрнүүлэн 50 бүлгийн 1759 хүүхэд 1000 номтой номын сантай боллоо.**

Үйлүүд 1 цагт зэрэгцэж болсон, зэрэгцэх нөхцөлөөр холбогдсон

Аяны хугацаанд Монголын шилдэг зохиолч, яруу найрагчдын хоёр удаагийн уулзалтаар 4 **зохиолчийг урьж, уулзалт, ярилцлага зохион байгуулж давхардсан тоогоор нийт 300 хүүхэд оролцсон байна.** “Номын баяр” аяныг “Боловсрол”, “Утга зохиол” сонин дэмжин оролцож мэдээлэл хийн, тусгай нэвтрүүлэг бэлтгэж “Ном” хөтөлбөрийг сурталчиллаа. “Номын баяр” аян төлөвлөсний дагуу үр дүнтэй боллоо.

Үйлүүд 1 цагт зэрэгцэж болсон, зэрэгцэх нөхцөлөөр холбогдсон.

Хянасан: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР(Д.Намсрай)
ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН БАГШ..... (Б. Цогзолмаа)

Нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгоё

Өгүүлбэрүүд нэг цагт зэрэгцэж болж байна уу? Цувж болж байна уу?

- 2 ба түүнээс дээш энгийн өгүүлбэрээс бүтэж байна.
- Өгүүлбэрүүд нь бие биедээ захирагдахгүй, тэгш эрхтэй
- Зэрэгцүүлэн холбох нөхцөлөөр холбогдсон байна.
- Өгүүлэхүүн тус бүр нь үйлийн эзэнтэй.
- Үйл явдал зэрэгцэж нэг цагт болж буй утга илтгэж байна.

ЗНӨ –ийн
онцлог

- ❖ Болжмор шувуу жиргэж, шугуй дунд бяцхан цагаан бялзуухай исгэрч, голын боргио шуугина.
- ❖ Манай байгууллага албан хэрэг хөтлөлтийн журмыг 2012 оны 08 сарын 31 –ны өдрөөс эхлэн мөрдөж, төлөвлөлт арга зүйн хэлтсийнхэн чиглүүлж, нарийн бичгийн дарга хянав.

- ❖ Болжмор шувуу жиргэнэ.
- ❖ Бяцхан цагаан бялзуухай исгэрнэ.
- ❖ Голын боргио шуугина.
- ❖ Манай байгууллага албан хэрэг хөтлөлтийн журмыг 2012 оны 08 сарын 31 –ны өдрөөс эхлэн мөрдсөн
- ❖ Төлөвлөлт арга зүйн хэлтсийнхэн чиглүүлсэн
- ❖ Нарийн бичгийн дарга хянасан.

Энгийн
өгүүлбэр

- Байрыг нь солин найруулж үзье. Утга нь өөрчлөгдөж байна уу? Ажиглая.
- Өгүүлбэрүүд юугаар холбогдож байна вэ?

Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

- Үйл явдлууд бие биеэсээ үл шалтгаалан , нэгэн цагт зэрэг болох өгүүлбэрүүдийг зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр гэдэг.

Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр бүтэх арга:

- Өгүүлбэрүүд хоорондоо аялгаар холбогдож зэрэгцдэг.
- Өгүүлбэрүүд үйлийн зэрэгцүүлэн холбох нөхцөлөөр холбогдоно

- ж, -ч , - н , - аад , -ээд, -оод, -өөд, - саар,сээр, соор, сөөр

- Өгүүлбэрүүд хоорондоо зэрэгцүүлэн холбох үгээр холбогдоно.

ба, буюу, бөгөөд, агаад, хийгээд, болон, болоод , харин, эсвэл, нэг бол, мөн байтугай

- 1.Өгүүлбэрүүдээс ЗНӨ–ийг ялган бичээрэй.
2. ЗНӨ мөн, бишийг батлан тайлбарлаарай.

- Аймгийн төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц. Б комисс томилон, тогтоолыг уншиж танилцуулаад, гишүүн Л.Т нь сэдвийг комиссын дарга Ж.Г-д хүлээлгэн өглөө.
- Бороо арилахад, наран гийж, солонго татна.
- Бид байгууллагатай хамтран ажиллаж, хүмүүс аймгийн төвийн гудамж талбайд мод тарьж, гэр хорооллын гудамжийг цэвэрлэж, нийтийн аж ахуйнхан цэвэр усны худгийг заслаа.
- Мянган хүний сэтгэлийг хөдөлгөхөд нэг дусал бэх хангалттай.
- Тэнгэрийн дуу нижигнэн, аянга цахилгаан гялбаж, шар гэрийн далан цоорхойгоор хүчтэй салхи исгэрнэ.

1. Аймгийн төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц. Б комисс томилон тогтоолыг уншиж танилцуулаад, гишүүн Л.Т нь сэдвийг комиссын дарга Ж.Г-д хүлээлгэн өглөө.
2. Бид байгууллагатай хамтран ажиллаж, хүмүүс аймгийн төвийн гудамж талбайд мод тарьж, гэр хорооллын гудамжийг цэвэрлэж, нийтийн аж ахуйнхан цэвэр усны худгийг заслаа.
3. Тэнгэрийн дуу нижигнэн аянга цахилгаан гялбаж, шар гэрийн далан цоорхойгоор хүчтэй салхи исгэрнэ.

Илтгэх хуудсыг уншаад ЗНӨ-ийг олж, ямар үүрэгтэй байгааг тайлбарлая

Сэлэнгэ аймгийн Мандал сумын сургууль

Илтгэх хуудас

Сайн үйлсийн аян зохион байгуулсан тухай

2017 оны 11 дүгээр сарын 03

Мандал сум

Тус сургуулийн “Сайн сайхны төлөө” клубын сурагчид эрүүл, цэвэр орчныг бүрдүүлэх зорилгоор сумын албан байгууллагуудад их цэвэрлэгээ хийж, тэднийг дэмжигч иргэд ч хашаагаа засаж будав.

Сайн үйлсийн аянд оролцогч сурагчид маань гудамж замд тэмдэглэгээ хийж, иргэдэд сурталчилан сумын удирдлага, иргэд тэдэнд талархал илэрхийлж, амжилт хүсэн, баяр хүргэлээ.

Сумын удирдлагуудад энэ санаачилгыг дэмжин сурагчдын клубт хувилах машин, компьютер, өнгөт принтер бэлэглэсэн бөгөөд ажлаа уламжлал болгохыг уриалав.

Илтгэх хуудас бичсэн клубын ахлагч Д. Хулан

Анхаарал тавьсанд баярлалаа